



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2018 оны 10 сарын 20 өдөр

Дугаар 493

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж,
данснаас хасах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх, журам"-ын 6.2.1, 6.4.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Санхүүгийн зохицуулах хорооны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, цаашид ашиглалтын шаардлага хангахгүй болох нь тогтоогдсон, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн нийт 1,989,403.00 (нэг сая есөн зуун наян есөн мянга дөрвөн зуун гурван) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. Санхүүгийн зохицуулах хорооны дарга С.Даваасүрэнд дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасаж, устгах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3. Энэ тогтоолын биелэлтийг 2018 оны 4 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.


ДАРГА

Ц.НЯМ-ОСОР

ЗАХИРГАА ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ГАВАА

0002387



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2018 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн
49 дугаар тогтоолын хавсралт

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ
АКТАЛЖ, ДАНСНААС ХАСАХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон он	Нэгжийн үнэ	Тоо ширхэг	Нийт үнэ	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл үнэ
1	Бичиг хэргийн хяналтын программ	2007	ш	1	116,400.00	116,400.00	0.00
2	Цагийн бүртгэлийн төхөөрөмж	2008	ш	1	759,024.50	759,024.50	0.00
3	Цаг бүртгэлийн программ	2008	ш	1	525,478.50	525,478.50	0.00
4	Вэб хуудас	2006	ш	1	588,500.00	588,500.00	0.00
НИЙТ ДҮН					1,989,403.00	1,989,403.00	-
					(нэг сая есөн зуун наян есөн мянга дөрвөн зуун гурван)	(нэг сая есөн зуун наян есөн мянга дөрвөн зуун гурван)	-